

ГАРЧИГ

ОРШИЛ	3
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	4
1.2. Төсөл хэрэгжүүлэх эрх зүйн орчин	4
1.3. Компанийн товч танилцуулга.....	4
1.4. Орд ашиглах тусгай зөвшөөрөл.....	4
1.5. Төслийн зорилго	5
1.6. Ордын байршил	5
1.7. Төслийн хүчин чадал.....	8
1.8. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдал	8
ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД.....	15
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	19
3.1.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.....	19
3.1.1.Үндсэн зорилго, зорилт	19
3.2.Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	20
3.2.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	20
3.2.1.1. Агаарын болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	20
3.3.Техникийн нөхөн сэргээлтийн зардал	23
3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	24
3.5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	24
3.6. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	25
3.7. Хог хаягдлын менежментийг төлөвлөгөө	26
3.8. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	26
3.8.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	28
3.9.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	30
3.10.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	31
ДҮГНЭЛТ	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2. Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь	17
Хүснэгт 3. Агаарын болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ	20
Хүснэгт 4. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, зардал	23
Хүснэгт 5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	24
Хүснэгт 6. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 7. Хог хаягдлын менежмент	26
Хүснэгт 61. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	27
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь	30
Хүснэгт 9. Компани удирдлагын зүгээс хийж гүйцэтгэх ажлууд	30
Хүснэгт 10. БОМТ-ний биелэлтийн тайланг хэлэлцүүлэх хуваарь	31
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгтгэл	33

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2. Төслийн талбайн байрзүйн зураг	5
Зураг 2. Төслийн талбайн фото зураг /2023.10.17/	6
Зураг 3. Төсөл хэрэгжих дүүргийн агаар, сансрын зураг	7
Зураг 5. Дээж авах мониторингийн цэгийн зураг	30

ОРШИЛ

Төсөл хэрэгжүүлэгч “Их ундарга майнинг” ХХК нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-011430 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Айлтын дээд хэсэг алтны шороон ордод олборлолтын үйл ажиллагааг явуулж, нөөцийг бүрэн ашиглаж дууссан байна. 2019 онд тус талбайд өөрийн хөрөнгөөр хайгуулын ажлыг хийж Улаан-Эрэгийн дарагдмал болон Айлтын жалга-1 алтны шороон ордод алтны нөөц тогтоосон байна. “Их ундарга майнинг” ХХК нь шороон ордын олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай компани бөгөөд уг тогтоосон нөөцөд тулгуурлан олборлолт ажлыг 2020 оноос явуулж эхэлсэн болно.

УУЯ, АМГ-ын ЭБМЗ-ын хуралдааны АМГ-ын даргын 2020 оны 05-р сарын 05-ны өдрийн Т/65 тоот тушаалын дагуу тус ордыг ашиглах “Техник эдийн засгийн үндэслэл” /ТЭЗҮ/-ийг боловсруулахаар шийдвэрлэн “Майнинг прожект консалтинг” ХХК-ийн баг ТЭЗҮ-г зохион Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтээр баталгаажуулсан байна.

Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Туулын баруун дэнж” нэртэй 226.71 га талбай бүхий MV-011430 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны хувьд Төв аймгийн Заамар сумын нутагт оршино. Улаанбаатар хотоос баруун хойш 250 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун хойш 22 км зайд байрлана.

Мөн манай компани нь Эрүүл мэнд байгаль орчин аюулгүй ажиллагааны дараах бодлогыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Ажиллагсдын ЭМААБО-ын талаарх хууль эрх зүйн болон дадлын мэдлэгийг тогтмол нэмэгдүүлэх, эрх бүхий байгууллагын сургалтанд үе шат ахиулан хамруулах,
- Ажиллагсдын эрүүл мэнд, түүний боловсролын мэдлэгийг хөгжүүлэх, эрүүл мэндийн бүрэн үзлэгт жил бүр хамруулах, анхан шатны тусламж үзүүлэх чадварыг хүн бүрт заавал эзэмшүүлэх, эм тариа, аптек, зориулалтын боолтоор хэсэг, нэгжийг бүрэн хангах,
- Аюулгүй ажиллагаа, түүний шаардлагыг бүрэн хэрэгжүүлж мөрдлөг болгон хэвшүүлэх,
- Амь нас эрсдэх, хөдөлмөрийн чадвар бүрмөсөн алдах гэмтэл, ажлын байрны аюул ослыг дүгнэх, сэргийлэх чадварыг хүн бүрт эзэмшүүлэх сургалт явуулах
- Байгаль орчинд үүсэх сөрөг нөлөөллийг тооцож сурах, анхны хэв шинжид нөхөн сэргээлт хийх ажилбар, зардлыг урьдчилан төлөвлөн тооцох, үе шатны төлөвлөгөө гаргах, тайлагнах,

- Хог хаягдал, ахуйн бохирыг журмын дагуу зайлуулах, устгах зэргийн баримтлан ажилладаг.

Төсөл хэрэгжүүлэгч нь төрийн бодлого, хууль журмыг сахин биелүүлж төслөөс учрах аливаа сөрөг нөлөөллийг Монгол улсын хууль журам, стандартын шаардлагад нийцүүлэн хамгийн бага түвшинд, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх үүрэгтэй.

НЭГ. ТӨСЛИЙН ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төв аймгийн Заамар сумын нутагт орших Айлтын жалга-1, Улаан-Эрэгийн дарагдмал алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэх эрх зүйн орчин

“Их ундарга майнинг” ХХК нь Монгол улсын бүртгэлд 9011702110 дугаартай бөгөөд Монгол улсад мөрдөгдөж буй хууль тухайлбал Үндсэн хууль, Газрын хэвлийн ашигт малтмалын тухай, Газрын төлбөрийн тухай, Татварын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Агаарын тухай, Усны тухай, Ойн тухай, Байгалийн ургамлын тухай, Химийн хорт бодисоос хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Галын аюулгүй байдлын тухай, Амьтны аймгийн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Аюултай хог хаягдлын импорт, Экспортын тухай, Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын тухай, Компанийн тухай, Гаалийн тухай, Газрын тухай, Хот байгуулалтын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай гэх зэрэг хуулийг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Компанийн төвч танилцуулга

“Их ундарга майнинг” ХХК нь 2017 онд байгуулагдсан бөгөөд Монгол улсын 9011702110 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй.

Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн Төв аймгийн Заамар сумын нутагт орших Туулын баруун дэнж нэртэй MV-011430 тоот ашиглалтын тусгай төвшөөрөлтэй 227 гектар бүхий талбайд, хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглах зөвшөөрлийг 2037.02.12 хүртэл авсан байна.

1.4. Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Туулын баруун дэнж” нэртэй 226.71 га талбай бүхий 2758X тоот ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг, АМХЭГ-ын ГУУКА-аас иргэн Ч.Сүхбаатарт 2000 оны 11-р сард анх олгосон байна. MV-011430 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2006 онд анх олгосон ба тусгай зөвшөөрөл эзэмшигчийг 2008 оны 07-р сард “Ньюпэрл” ХХК болгон өөрчилсөн байдаг. Улмаар ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг АМГТГ-ын КХ-ийн даргын 2018 оны 02-р сарын 14-ний өдрийн 86 тоот шийдвэрээр “Их ундарга майнинг” ХХК-д шилжүүлсэн байна.


1.5. Төслийн зорилго

Төсөл хэрэгжүүлэгч “Их ундарга майнинг” ХХК нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-011430 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Айлтын дээд хэсэг алтны шороон ордод олборлолтын үйл ажиллагааг бүрэн явуулж дууссан байна. 2019 онд тус талбайд хайгуулын ажлыг хийж Улаан эрэгийн дарагдмал болон Айлтын жалга-1 алтны шороон ордод алтны нөөц тогтоосон байна. “Их ундарга майнинг” ХХК нь шороон ордын олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай компани бөгөөд уг тогтоосон нөөцөд тулгуурлан олборлолт ажлыг 2020 оноос явуулахаар төлөвлөж байгаа болно.

Иймд уг ордыг Монгол Улсын хууль, холбогдох дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайн ашиглалтыг явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

1.6. Ордын байршил

“Их ундарга майнинг” ХХК-ны MV-011430 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Туулын баруун дэнж нэртэй талбай нь Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн нутагт байрлах бөгөөд сумын төвөөс баруун хойш 22 км, Улаанбаатар хотоос баруун хойш 250 км зайд тус тус оршино. Талбай нь номенклатурын хувьд L-48-126 нэрэлбэрт байрладаг.



Зураг. Төслийн талбайн байрзүйн зураг



Зураг 1. Төслийн талбайн фото зураг /2023.10.17/

ЭБМЗ-ийн Т/Ц-03-05 Дугаар дүгнэлтийн хавсралт

Төв аймгийн Заамар сумын нутагт орших Туулын баруун дэнж нэртэй MV-011430 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд орших Айлтын жалга-1, Улаан-Эрэгийн дарагдмал алтны шороон ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Нөөцийн зэрэг, хэсэгшлийн дугаар	Геологийн нөөц								Уурхайн хүрээний гадна үлдэх нөөц						Ашиглалтын нөөц					Бохирдол		Үйлдвэрлэлийн нөөц										
	Хэсэгшлийн талбай, мян.м ²	Хөрсний дундаж зузаан, м	Элсний дундаж зузаан, м	Хөрсний эзлэхүүн, мян.м ³	Элсний эзлэхүүн, мян.м ³	Алтны дундаж агуулга, мг/м ³	Алтны нөөц шлихээр, кг	Алтны нөөц химийн цэврээр, кг	Хэсэгшлийн талбай, мян.м ²	Хөрсний эзлэхүүн, мян.м ³	Элсний эзлэхүүн, мян.м ³	Алтны дундаж агуулга, мг/м ³	Алтны нөөц шлихээр, кг	Алтны нөөц химийн цэврээр, кг	Хэсэгшлийн талбай, мян.м ²	Хөрсний эзлэхүүн, мян.м ³	Элсний эзлэхүүн, мян.м ³	Алтны дундаж агуулга, мг/м ³	Алтны нөөц шлихээр, кг	Алтны нөөц химийн цэврээр, кг	Хувь, %	Элсний эзлэхүүн, мян.м ³	Үйлдвэрлэлийн нөөцийн зэрэг	Уурхайн хажуугийн тэлэлтээс нэмэгдэх хөрсний эзлэхүүн, мян.м ³	Хөрсний нийт эзлэхүүн, мян.м ³	Элсний эзлэхүүн, мян.м ³	Алтны дундаж агуулга, мг/м ³	Алтны нөөц шлихээр, кг	Алтны нөөц химийн цэврээр, кг			
Айлтын жалга - 1 орд /Сорьц-917/																																
С-1	2.99	2.1	1.3	6.2	4.0	529	2.11	1.93	0.10	0.20	0.13	529	0.07	0.06	2.89	6.0	3.9	529	2.04	1.87	24.94	0.96	В-1'	0.5	6.5	4.8	423	2.04	1.87			
В-1	10.37	2.4	1.1	25.3	11.2	487	5.46	5.01							10.37	25.3	11.2	487	5.46	5.01	28.90	3.24	В-1'	2.8	28.1	14.4	378	5.46	5.01			
В-2	9.80	3.3	0.9	32.3	8.3	502	4.19	3.84							9.80	32.3	8.3	502	4.19	3.84	36.59	3.05	В-2'	3.4	35.7	11.4	368	4.19	3.84			
В-3	7.60	4.1	0.9	31.2	6.8	391	2.67	2.45							7.60	31.2	6.8	391	2.67	2.45	35.01	2.39	В-3'	38.9	70.0	9.2	289	2.67	2.45			
Нийт	30.76	3.1	1.0	95.0	30.4	475	14.42	13.23	0.10	0.20	0.13	529	0.07	0.06	30.7	94.8	30.2	475	14.36	13.17	31.89	9.64	Нийт	45.5	140.3	39.9	360	14.36	13.17			
В	27.77	3.2	0.9	88.8	26.4	467	12.32	11.29	-	-	-	-	-	-	27.8	88.8	26.4	467	12.3	11.3	32.91	8.7										
С	2.99	2.1	1.3	6.2	4.0	529	2.11	1.93	0.10	0.20	0.13	529	0.07	0.06	2.9	6.0	3.9	529	2.0	1.9	24.94	1.0										
Улаан-Эрэгийн гүний дарагдмал орд /Сорьц-931/																																
С-1	2.80	25.4	1.7	71.1	4.7	937	4.37	4.07							2.80	71.1	4.7	937	4.37	4.07	21.50	1.00	В-1'	53.0	124.1	5.7	772	4.37	4.07			
В-1	8.85	27.3	1.7	241.3	15.0	801	12.05	11.21							8.85	241.3	15.0	801	12.05	11.21	19.54	2.94	В-1'	136.4	377.7	18.0	670	12.05	11.21			
В-2	11.91	31.1	1.7	369.9	19.7	823	16.24	15.12							11.91	369.9	19.7	823	16.24	15.12	19.59	3.87	В-2'	133.3	503.2	23.6	688	16.24	15.12			
В-3	6.90	36.3	1.7	250.4	12.0	909	10.93	10.18							6.90	250.4	12.0	909	10.93	10.18	19.08	2.29	В-3'	151.9	402.2	14.3	763	10.93	10.18			
В-4	5.41	45.8	1.8	247.6	9.7	924	9.00	8.38							5.41	247.6	9.7	924	9.00	8.38	19.12	1.86	В-4'	278.8	526.4	11.6	776	9.00	8.38			
С-2	2.77	52.4	1.6	145.1	4.4	1,029	4.56	4.25							2.77	145.1	4.4	1,029	4.56	4.25	23.12	1.02	В-2'	424.0	569.1	5.5	836	4.56	4.25			
Нийт	38.64	34.3	1.7	1,325.4	65.6	871	57.15	53.21	-	-	-	-	-	-	38.64	1,325.4	65.6	871	57.15	53.21	19.79	12.99	Нийт	1,177.4	2,502.8	78.6	727	57.15	53.21			
В	33.07	33.5	1.7	1,109.1	56.5	853	48.22	44.89	-	-	-	-	-	-	33.1	1,109.1	56.5	853	48.2	44.9	19.39	11.0										
С	5.57	38.8	1.6	216.3	9.1	982	8.94	8.32							5.6	216.3	9.1	982	8.9	8.3	22.29	2.0										
Ордын хэмжээнд																																
Бүгд	69.40	20.5	1.4	1,420.4	96.0	746	71.58	66.44	0.10	0.20	0.13	529	0.07	0.06	69.3	1,420.2	95.9	746	71.5	66.4	23.61	22.63	Бүгд	1,222.9	2,643.1	118.5	603	71.51	66.37			
В	60.84	19.7	1.4	1,197.9	82.9	730	60.53	56.18	-	-	-	-	-	-	60.8	1,197.9	82.9	730	60.5	56.2	23.69	19.6										
С	8.56	26.0	1.5	222.4	13.1	844	11.05	10.25	0.10	0.20	0.13	529	0.07	0.06	8.5	222.2	13.0	847	11.0	10.2	23.08	3.0										

ЭБМЗ-ийн 2019 оны 12-р сарын 10-ны өдрийн ХХ-18-05 тоот дүгнэлтээр хүлээн авсан нөөцөд үндэслэн тооцлоо. Орд нь III бүлгийн орд тул Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын дагуу (В+С) зэргийн нөөцөд тулгуурласан. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд В+С зэргээр 96.0 мян.м³ элсний нөөц байх ба элсэнд агуулагдах алтны хэмжээ химийн цэврээр 66.44 кг байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хил болон уурхайн эцсийн хүрээгээр Айлтын жалга-1 ордын, С-1 блокоос 1.77 мян.м³ элсний нөөц хязгаарлагдах ба элсэнд агуулагдах алтны хэмжээ химийн цэврээр 0.26 кг байна. Уурхайн хүрээнд багтах нөөцийг Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын дагуу нөөцийн шинэ ангиллаар, магадалсан В' зэрэгт шилжүүлж тооцлоо.

Нөөцийн тооцоог хийсэн: Уулын инженер.....Ч.Эрдэнэбаяр/

Хянасан: АМГТГ-ын УУУТХ-ийн, Ашигт малталын нөөцийн хөдөлгөөн, бүртгэл хариуцсан мэргэжилтэнЦ.Золзаяа/

Зураг 2. Төсөл хэрэгжих дүүргийн агаар, сансрын зураг

1.7. Төслийн хүчин чадал

2019 онд “Их ундарга майнинг” ХХК тус талбайд өөрийн хөрөнгөөр хайгуулын ажлыг хийж Улаан-Эрэгийн дарагдмал орд болон Айлтын жалга-1 алтны шороон ордод алтны нөөц тогтоосон байна. Ордын геологийн нөөцийг Улаан-Эрэгийн дарагдмал ордод В+С зэрэглэлээр 65.64 мян.м³ элс буюу 53.21 кг алтны нөөц /химийн цэврээр/, Айлтын жалга-1ордод тогтоож В+С зэрэглэлээр 32.00 мян.м³ элс буюу 13.43 кг алтны нөөц /химийн цэврээр/, талбайн хэмжээнд В+С зэрэглэлээр 97.0 мян.м³ элс буюу 66.44 кг алтны нөөц /химийн цэврээр/-ийг тогтоож Улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

Ордыг ил аргаар ашиглах бөгөөд ил уурхайн хүрээнд нийт 2.75 сая.м³ уулын цул багтаж, ил аргаар ашиглах үеийн хаягдал, бохирдол тооцсоноор нийт үйлдвэрлэлийн нөөц 117.3 мян.м³ элс болж байна. Ил уурхай жилд 50.0 мян.м³ элс олборлох хүчин чадалтай ажиллах ба уурхайн ашиглалтын хугацаа 2-р жил байна.

Төсөл хэрэгжсэнээр 2.01 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 71 хүний ажлын байр бий болох бөгөөд улсын төсөвт 948.7 сая төгрөгийн татвар төлж 2.56 тэрбум төгрөгийн ашигтай ажиллахаар байна.

1.8. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдал

Энэ орчны уур амьсгал бүрэлдэн тогтох онцлог нь баруунаас зүүнрүү чиглэлтэй Цээлийн уудам цэлгэр хөндий, өмнө болон зүүн баруунаараа Их Загцаг болон Их Сэрвэн уулс зэрэг бэсрэг уулсаар хүрээлэгдсэн тэдгээрийн эхнээсээ бэлрүүгээ талбиун болсон 2 талаараа дэнж хэрчигдэл бүхий төдийлөн гүн биш ам жалганууд нь эндхийн ерөнхий болон бичил уур амьсгал бүрэлдэх дэвсгэр гадаргын нэгэн зүй тогтол болж байна. Энэ нь агаар мандлын ерөнхий орчил урсгалд төдийлөн нөлөөлөхгүй харин орон нутгийн бичил салхи агаарын урсгал үүсэхэд нөлөөлөх тал бий.

Жилийн дундаж агаарын температур $-0.3-0.5^{\circ}\text{C}$ хооронд байдаг нь уулын энгэр бэл, өндөрлөг уужим амнууд хавьд өргөн хоолойгоос сэрүүн Туул голын хөндий учир багавтар цэвдэгтэй, хөрсний хөлдөлт харьцангуй их болдог. Мөн голын хөндийн салхины улмаас жаварлаг хайруу, гол уулын хөндийн салхины нөлөөтэй байх бичил уур амьсгалын онцлогтой. Агаар, хөрсний температурын хоног ба жилийн явц нь нар улирлаа дагаж байдаг. Тухайлбал агаарт 7 дугаар сард 18.0°C байхад хамгийн хүйтэн 1 дүгээр сард -24.0°C байдаг. Хаврын дулааралт, намрын сэрүүсэлтийн явц эсрэг тэсрэг дулаан хүйтний тэгш хэмийн явцтай эх газрын уур амьсгалын нэгэн онцлог юм. Эндхийн уур амьсгал нь эх газрын эрс тэс, хахир ширүүн, хуурайдуу хүйтэвтэр жилийн 4 улирлын хэв шинжийн

онцлогтой. Зуны улиралд хур бороо ихсдэг. Харин намрын улирал зуны улиралын төгсгөлөөс 11-р сарын 6 хүртэл үргэлжлэх ба энэ үед хүйтэн нэмэгдэж, цас мөс үүсэн, газар шороо хөлдөж эхэлдэг.

1.8.1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний товч тодорхойлолт

Төслийн үйл ажиллагааны үед орчны агаарын чанарт дараахи байдлаар нөлөөлж болзошгүй.

- о Барилга байгууламж барих, элс олборлох, хөрс хуулах, хөрс тээвэрлэх гэх мэт үйл ажиллагааны үед тоосжилт үүснэ.
- о Уулын ажлын хөрс хуулалт, тээвэрлэлт, овоолгоос жилд 289 тн тоос үүсэж агаар бохирдуулахаар байна.
- о Уурхай дахь тээврийн хэрэгсэл болон автомашины хөдөлгүүрийн дутуу шаталтын хий нь агаар орчныг хорт хийгээр бохирдуулж болзошгүй.
 - о Тоосжилт, хорт хийн ялгаралт, тэсэлгээнээс үүдэх дуу шуугиан гэх мэтээс шалтгаалан төсөл хэрэгжих орчны айл өрхийн амгалан тайван байдал алдагдаж, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй.

Агаарын чанарт төслийн дээрхи үйл ажиллагаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад дараах арга хэмжээг авна.

- о Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. Стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авах;
 - о Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах;
 - р Тоосжилт тархах хүрээ ачиж, тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчимд байхаар зам, овоолгын байршлыг оновчтой сонгох, улмаар байнгын ажлын байрнаас зайдуу байршуулах хэрэгтэй.
- о Уурхайн дотоод тээвэрлэлтийн автозамуудыг тоос бага гаргадаг материалаар өнгөлөх, байнга усалж байх, ялангуяа тоосжилт, шороон шуурганы гаралт нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд төслийн талбайг усаар норгох, чийглэх, өвөл нь автогрейдрээр тэгшлэх, орсон цасыг замын элстэй хольж, тэгшлэн дагтаршуулах;
 - о Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, элсний тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх;
- о Уурхайд ашиглах тоног төхөөрөмжийн сонголтыг хийхдээ ялгаруулалтын стандартууд болон түлш зарцуулалтын үр ашгийг нь харгалзан үзэх.
 - о Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх.
- о Тээврийн хэрэгсэлд хорт хийг бууруулах шүүлтүүр суурилуулах.

о Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслыг тогтоосон хугацаанд нь сольж байх

1.8.2. Газрын гадарга, хэвлий, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээний тойм

“Айлтын жалга-1 болон Улаан эрэг”-ийн алтны шороон ордын олборлолтын үйл ажиллагаанд дараах чулуулгууд өртөнө. Төслийн олборлолтын үйл ажиллагааны нөлөөллөөр уурхайн хэмжээнд нийт 25,1 га талбайг хамарсан дунджаар 20 м-ийн гүнтэй ухаш үүснэ. Сөрөг нөлөөллийн үнэлгээний тооцооноос үзэхэд төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, геологийн тогтоцод үзүүлэх нөлөөлөл нь сул зэрэглэлд хамарч байна.

Ашигт малтмал олборлох явцад газрын гадарга, газрын хэвлий ихээхэн эвдрэлд орох бөгөөд сөрөг нөлөөллийг арилгахын тулд дараах арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй. Үүнд:

- Энэхүү тайлангийн эрхзүйн мэдээллийн хэсэгт бичигдсэн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн стандартуудыг баримтлах
- Тайлангийн төгсгөлд бичигдсэн нөхөн сэргээлтийн төслийг хэрэгжүүлэх

1.8.3. Хөрсөн бүрхэвч, түүнд үзүүлэх сөрөг нөлөөл, бууруулах арга хэмжээний товч тодорхойлолт

Төв аймгийн Заамар сумын нутагт байрлах MV-011430 лицензийн талбай болон нөлөөллийн бүсийн хэмжээнд хөрсний төлөв байдлыг тодруулах зорилгоор хээрийн судалгааг 2020 онд хийж гүйцэтгэсэн. Үүнд: хөрсний гадаргын төлөв байдал, хөрсний үе давхаргын морфологи шинж чанар, хөрсний үржил шимийн түвшин, хөрсний хими, физик шинж чанарыг тодруулах зорилгоор 3 зүсэлт, 1 ухалт хийн хөрсний 3 ширхэг дээж авсан хөрсний ижил хэв шинжийг харгалзан бусад талбайнуудад хөрсний гадаргын бичиглэл хийлээ.

Алтны шороон орд орчмын хөрс уулын хүрэн шороон хөрс , урвалын орчин шүлтлэг (рН 6,25-8,10) ялзмагийн агууламж 0,7-27,6 %, элсэнцэр, хар хүрэн хөнгөн механик бүрэлдэхүүнтэй, бөөмөнцөр бүтэцтэй хөрс болно.

Төслийн үйл ажиллагааны улмаас хөрсөн бүрхэвчинд дараах байдлаар сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

- Уурхайн ашиглалтын хугацаанд нийт 50446,04 сая.м³ хөрс хуулна.
- Хүн, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, хөрсний шороо суларч, элэгдэл эвдрэлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй.
- Бензин, тос, дизелийн асгаралт, шүүрэлт мөн үйлдвэрлэлийн болон, ахуйн хэрэглээний хог хаягдлаас хөрсний бохирдол үүснэ.

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн ажлын хэмжээг тодотгон, шаардагдах зардлыг тооцож байх
- Нөхөн сэргээгдэж буй газар, түүний хүрээлэн буй орчин нь олборлолтын дараа байгалийн тэнцвэрт байдлаа хадгалсан, унаган төрхөндөө ойртсон, хүн амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх нөхцлийг аль болох эртнээс төлөвлөх, уурхайн ашиглалттай зэрэгцүүлэн эхлүүлэх
- Гадаад овоолго хийх талбайг үржил шим багатай, байгалийн нөлөөгөөр эвдэрсэн, гуу жалгатай газрыг сонгон орчны гадаргуутай ландшафтын хэлбэршлийн хувьд нэгдмэл бүтэц бий болгоход анхаарах нь чухал.
- Нөхөн сэргээлтэд хэрэглэх үржил шимт хөрсийг үер бороо, уруйн усанд зөөгдөж урсахааргүй суваг шуудуу жалганы голдирлоос зайдуу газарт хийж түрж овоолго хийх хэрэгтэй
- Хөрсний эмзэг шинж чанарыг харгалзан олборлолтын эхнээс авто замын сүлжээг оновчтой зохион байгуулах, тогтсон маршрутаар цуваа байдлаар механизм, техник тоног төхөөрөмж, материалыг тээвэрлэх

1.8.4. Ургамлан бүрхэвч, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний товч

Төслийн талбай нь ургамал газарзүйн мужлалаар Евро азийн шилмүүст ой, нуга хээрийн их муж, чийглэгдүү хэвшинжийн Дорнод Азийн муж, Орхон-Туулын нам уулсын тойрогт хамаарагдана (Монгол улсын Үндэсний атлас, 2009). Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангайн уулт их муж, Орхон Туулын савын бэсрэг уулсын муж, Орхон-Ерөө голын тойрогт багтана (Даш, 2000).

Уулын хээрийн энэ бүс нутагт үетэн-алаг өвст, үетэн-шарилжит, сөөг-алаг өвст бүлгэмдлүүд зонхилно. Эдгээр бүлгэмдлүүд дотор хялгана, биелэг өвс, шарилж зонхилохоос гадна харгана, тавилгана, боролзогоно зарим газартаа одой хайлаас зэрэг ургамлууд уулын бэл хажуу, дээд хэсэг, гуу жалгаар ургана. Мөн хэсэг газарт дэрст бүлгэмдэл тохиолдоно.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн эх үүсвэр нь олборлолтын үйл ажиллагаа, дотоод болон тээвэрлэлтээс үүсэх тоосонцор, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх ухаш, гадаад овоолго болон бусад объектын нөлөөгөөр ургамлан нөмрөг устгах буюу доройтолд орно.

Төсөл хэрэгжиж дууссаны дараа нөхөн сэргээлтийн зөвлөмжинд заасны дагуу мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх хэрэгтэй.

1.8.5. Усан орчин, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний товч

Гадаргын ус: Судалгааны талбайд Орхон голын баруун цутгал болох Туул гол нь талбайн хамгийн том гол юм. Туул гол нь нийтдээ 600 орчим км бөгөөд өргөн нь 1-4 км хооронд хэлбэлзэж байдаг.

Талбайн хэмжээнд Хайлааст, Баянгол, Хар бух, Ар Наймган зэрэг маш олон цутгалууд бий боловч ордын хэмжээнд Туулын гол руу зүүн гар талаар нь цутгаж байгаа Өвөр Тээлийн гол юм. Энэхүү цутгалын хөндий хуурай сайртай зөвхөн цас хайлсны дараа болон ширүүн борооны дараа богино хугацааны горхи урсана.

Ордын орчимд Туул голын хөндийн тэвш маягийн хэлбэртэй, 0.8-2.5 км өргөнтэй арай огцом налуу баруун, налуувтар зүүн энгэртэй. Гольдрил нь ихээхэн тахиралдсан байх ба олон тооны цутгал болон арлуудтай. Гольдрилын өргөн нь 30-100 м, гүн нь 0.5-1.6 м хааяа 2.2 м хүрнэ. Урсгалын хурд секундэнд 0.3-1.1 м. хөндийн гадаргын хэвгий 0.001-0.002. Туул голын ус нь цас борооны ус нэмэгдэж үерлэх үед шаврын хольц нэмэгдснээс шаравтар өнгөтэй байдаг бол хамгийн цэвэр үедээ ногоовтор өнгөтэй байдаг нь Улаанбаатар хотын хэрэглээний усыг цэвэршүүлсний дараа нийлүүлсэнтэй холбоотой.

Айлтын жалга-1, Улаан эргийн дарагдмал алтны шороон орд нь Монгол орны гидрогеологийн дүүрэгчлэлээр хойд системийн Туул голын ай савд багтдаг. Гидрогеологийн хойт системийн ай савуудад ихэвчлэн газар доорх усны грунтын ус зонхилон тархсан байдаг. Энэ сав газар нь томоохон суурин газруудын төвлөрсөн усан хангамжийг шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Уурхайн үйл ажилгааны улмаас гүний усны хомсдол үүсэж, гол горхи ширгэх зэрэг сөрөг нөлөө гарч магадгүй. Шүүрлийн усыг тогтмол ажиглаж, шүүрлийн усаар зам талбайг услах, технологид хэрэглэх зэргээр ашиглана.

1.8.6. Амьтны аймаг, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний товч

Судалгааны талбайн орчимд хийсэн судалдаанд тулгуурлан амьтны аймгаас хамгийн өргөн тархсан 39 зүйлийн шавьж, 18 зүйлийн шувуу, 3 зүйлийн хөхтнийг олж тодорхойлсон. Эдгээрийн дотор Монгол улсын Улаан номонд орсон ховор, ховордож буй, Вашингтоны конвенци (CITES)-ийн 2-р хавсралтанд хамрагдсан амьтан байхгүй болно. Энэ орчимд шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (*P.domesticus*) ба хээрийн

(P.montanus) бор шувуу, хөхвөр тагтаа (C.livia), сохор элээ (Milvus migrans), шаазгай (Pica pica), улаан хошуут (Pyrrhcorax pyrrhcorax), хар хэрээ (Corvus corone), хон хэрээ (corvus corax) арай олон үзэгдэж байна. Хөхтний дотроос урт сүүлт зурам (Citellus undulatus), дагуур огодой (Ochotona daurica), бэсрэг атаахай (Sorex daphacnodon), цармын атаахай (Sorex tundrensis Merria), сахалт баавгай (Moytis mystacinus Kuhl), бор туулай (Lepus total Poll), ойн хүрэн оготно (Ceeth roinomus rufocanus sund), ширчийн оготно (Microtus maximovichii Schr), саарал чоно (Canus Lupus), шар үнэг (Vulpes L.), дорго (Meles L.), цагаан үнэг (Mustela ermine L.) зэрэг бүртгэгдсэн байна. Шавьжийн ангиас голдуу төрөл бүрийн цохын овог тааралдана.

Мөн олон салаа зам үүсгэх, техникийн ажиллагаагаар хөрс сулралт явагдах зэргээс үүдэн хүн, машин техникийн зам харгуйн тоо ихсэх, эрүүл газар талхлагдах зэргээр ургамлан бүрхэвч доройтох хандлагатай байна. Ил уурхайн нэг цогц байгууламж байрлаж буй 24 га талбайд амьтан байх боломжгүй бөгөөд эргэн тойронд тодорхой байгууламжууд баригдан хүмүүсийн суурьшил бий болж зам харгуй, чимээ шуугиан, утаа гэх мэтийн олон хүчин зүйл зэрлэг амьтдад сөрөг нөлөө үзүүлнэ.

1.8.7. Талбайн алтны шороо ордын геологийн тогтоц

Заамарын хүдрийн зангилаа Айлтын жалга-1 болон Улаан эргийн дарагдмал алтны шороон орд Хойт Хэнтийн алтжилтын бүсэд хамаарах Заамарын хүдрийн зангилааны баруун хойт хэсэгт оршино. Заамарын хүдрийн зангилаа буюу дээр дурдсанчлан Заамарын метаморф-интрузив бүнхэр нь Монгол улсын тектоникийн мужлалаар Хангай Хэнтийн атираат мужийн Хойт Хэнтийн өргөгдөлд (Тектоническая карта МНР, 1978), ороген тектоникийн мужлалаар Хэнтий-Даурын их төвөн өргөгдлийн Хойт Хэнтийн бүсэд (Карта орогенной 1986), плит тектоникийн ангилалаар Хойт Хэнтийн турбидиттэй террейнд (О.Төмөртогоо, 1997) байрлана.

Заамарын хүдрийн зангилааны алтны хүдэржилтийн геолог структурийн нөхцөлийг эрдэмтэн Ш.Энхбаатар судалж үзээд энэхүү метаморфоген-гидротермаль тархалт нь Заамарын метаморф-интрузив бүнхэрийн метаморфизмын бүслүүржилт болон антиклиналь атирааны цөмөөр, үйлдвэрийн ач холбогдол бүхий мезотермаль хүдэржилт нь антиклиналь атираа болон агуулагч чулуулагтай бараг нийцлэг хагарлаар мезозойн гидротермаль эрдэсжилт нь зүүн хойш чиглэлтэй Баянгол, Галт-Хайлааст, Заамарын тектоник хаграл, бутралын бүсүүдээр тус тус хянагдаж байна гэж үзсэн байна.

Энэхүү хүдрийн зангилааны хэмжээнд Бумбат, Нарийн гол, Галт зэрэг хэд хэдэн хүдрийн талбай ялгаснаас тэдгээрийн хэмжээнд Бумбат, Баруун шанд, Хайлааст, Ар наймган, Нарийн гол зэрэг цахирын судал бүхий алтны үндсэн ордууд, Шар гозгор, Мануухайт, Баянгол, Бага Хайлааст, Цагаан чулуут, Доргонт зэрэг олон арван үндсэн

илрэлүүд, Тосон, Туул, Баянгол, Хайлааст, Ар наймган, Цагаан булаг, Өгөөмөр, Тосонгийн гол зэрэг том жижиг 30 орчим алтны шороон ордуудыг илрүүлэн хайгуулыг нь үндсэн нь дуусган олборлож байна. Эдгээр алтны шороон ордууд голын хөндийд хуримтлагдсан неоген болон дөрөвдөгчийн хурдсанд нэг хоёр алтны давхаргыг үүсгэн газрын гадаргаас 2-35 м хүртэл гүнд оршино. Алтны дундаж агуулга хэдэн зуун мг-аас 5 г/шоо м хүрнэ.

1.9. Нийгэм эдийн засаг, учруулах нөлөөлөл

Айлтын жалга болон Улаан эргийн дарагдмал алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл нь Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт хэрэгжихээр төлөвлөгдөж байгаа.

Төв аймгийн Заамар сум

Тус сум нь Улаанбаатар хотоос 180 км, Төв аймгийн төвөөс 225 км алслагдан оршдог бөгөөд 280.3 мянган га нутаг дэвсгэртэй. Заамар сум нь 2012 оны байдлаар 1563 өрх, 5345 хүн, 193631 толгой мал тоолуулсан байна. Суманд 9 болон 12 жилийн дунд сургуульд 1200 гаруй сурагчид, МСҮТ-д 400 гаруй оюутан суралцдаг ба 160 гаруй багш ажилладаг. Мөн хүн, мал эмнэлэг салбар, цэцэрлэг яслы, соёл урлагийн цогцолбор, халуун ус, саун, үсчний газар, худалдаа үйлдвэр үйлчилгээний цэгүүд, газар тариалангийн чиглэлийн компани, хоршоо, нөхөрлөл, ХААН банк, холбооны салбар зэрэг 20 орчим аж ахуйн нэгж, 20 гаруй худалдаа үйлчилгээний цэг, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг 14 аж ахуйн нэгж байдгаас гадна жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор талх нарийн боов, оёдол эсгүүр, эсгий эсгийний, мод модон эдлэлийн цех, блок хавтангийн цехүүд тус тус ажиллаж байна.

Төслийн татвар хураамжаар орон нутгийн орлого нэмэгдэх бөгөөд үүний үр дүнд тухайн орон нутгийн нийгмийн үйлчилгээнд хөрөнгө оруулалт болно.

- Уурхайн нүх, овоолго, барилга байгууламж, зам зэрэг үйл ажиллагаа нь бэлчээрийн 25.1 га талбайг эзэлнэ.
- Төсөл хэрэгжих бүх жилийн хугацаанд НӨАТ, НДШ, ХАОАТ, ашгийн татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар, тусгай зөвшөөрлийн төлбөр, байгалийн баялаг ашигласны төлбөр, ашгийн татвар гэх мэт татварыг улсад төлнө.

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД

Төв аймгийн Заамар сумын нутагт “Их ундарга майнинг” ХХК-ийн хэрэгжүүлж буй айлтын жалга-1, Улаан эрэгийн алтын шороон ордыг ил аргаар ашиглах төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан, БОНХЯ-наас гаргасан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц, магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны арга, зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

Сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй нөхцөлүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга зам
Агаарт үзүүлэх сөрөг нөлөө	
<p>Алтны шороон ордыг ашиглах үед хөрс хуулах, элс олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрийн үйл ажиллагаанд өртсөн ухаш, овоолгын талбай зэргээс салхинд хийсэх тоос агаар орчныг бохирдуулахаас гадна техник тоног төхөөрөмжийн дуу чимээ, ахуйн хог хаягдал, бохирын үнэр нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах. - Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. - Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, элсний тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх. - Уурхайн дотоод тээвэрлэлтийн автозамуудыг байнга усалж байх, ялангуяа тоосжилт, шороон шуурганы гаралт нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд төслийн талбайг усаар норгох, чийглэх. - Хучлага ашиглах - Тээврийн хэрэгслийн дээд хурдыг 40 км/ц-аас хэтрүүлэхгүй байвал замаас үүсэх тоосжилтын 44 хувиар бууруулна.
Хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөө	
<p>Төслөөс уурхайн карьер ба овоолго үүсгэх, барилга байгууламж барих, зам, шугам сүлжээ тавих зэрэг үйл ажиллагаагаар нийт 25.1 га талбай эвдрэлд орохоос уурхайн шууд олборлолтонд өртөх 14,1 га талбайн ургамлан нөмрөг хөрсөн бүрхэвчтэй хамт хуулагдан, шууд нөлөөлөлд өртөж үгүй болно. Энэ нь төслийн нийт талбай нь 11.5 хувийг эзэлж байна. Мөн техникийн засвар үйлчилгээ, хог хаягдлын цэг зэргээс хөрс, ургамал</p>	<ul style="list-style-type: none"> - Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх, ашигласан тос масло, аккумулятор, дугуй зэргийг нийлүүлэгчид гэрээний дагуу буцааж өгөх, - Уурхайн технологийн дотоодын болон гадаад тээвэрлэлт, үйлчилгээний зориулалтын тээврийн хэрэгсэлийн зорчих сайжруулсан зам, талбайг иж бүрэн тэмдэгжүүлэн, тээврийн хэрэгсэл, уулын машин механизмын хөдөлгөөнийг заасан маршрутаар хязгаарлах, - Уурхайн олборлолтод өртөх талбайн ургамлын бүрхэвч бүхий өнгөн хөрсийг хуулж, нөхөн

<p>бохирдоно.</p>	<p>сэргээлтэд зориулан стандартын дагуу хадгалж, ашиглах</p> <ul style="list-style-type: none"> - Хэт хуурайшилттай, салхи ихтэй нөхцөлд газрыг чийглэж услаж байх - Хог хаягдлын цэгийг тогтмол ариутгаж, орон нутгаас заасан хогийн цэгт хүргэж байх
<p>Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөө</p>	
<p>Айлтын жалга-1, Улаан эргийн алтны шороон ордыг олборлох төслийн хэрэгжилтийн үе шатуудад газрын болон гадаргын усны чанарт нөлөөлж бохирдуулах эх үүсвэр дунд зэрэг юм. Төслийн хугацаанд нийт 133,859.26 мян.м³ ус шаардагдах ба үүний 79% эргэлтийн нуураас эргүүлэн ашиглаж 21% буюу 28110,4 мян.м³ усыг нөхөн сэлбэнэ. Төслийн талбайд гаргасан гүний худгаар ахуйн хэрэгцээгээ хангах бөгөөд баяжуулах үйлдвэрийн усыг 3.2 км-т байх Туул голоос насосоор татаж хангана.</p>	<ul style="list-style-type: none"> - Шүүрлийн усыг хуримтлуулан технологийн усны хэрэглээнд ашиглах, зам усалгаанд ашиглах, Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглах - Бохир ус, элдэв хог хаягдлыг сайр, судгийн гулдрилд хаяж, бохирдол бий болохоос урдчилан сэргийлэх арга хэмжээг талбайд аливаа үйл ажиллагаа явуулж эхлэхээс анхааран хэрэгжүүлэх шаардлагатай - Ундны усны эх үүсвэрт тогтмол хими-бактерологийн шинжилгээ хийлгэж шаардлага хангаж байгаа эсэхийг тогтмол хянаж байх - Ахуйн хэрэглээний ус зөөлрүүлэгч төхөөрөмжийг цаг тухай бүрд нь шинэчлэн завсарлж байх
<p>- Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө</p>	
<p>Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, дуу чимээ нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Ажилтан нь хөдөлмөр хамгааллийн хэрэгслээ тогтмол хэрэглэж хэвших - Ажилтнуудаа нэгдсэн журмаар эмнэлгийн үзлэгт хамруулах

Төсөл хэрэгжиж буй орчмын нутаг дэвсгэрт учирч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг байгалийн хам бүрдлүүдтэй уялдуулан тодорхойлж хүснэгт 2.-д үзүүлэв.

Хүснэгт 1. Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
<u>Нэг. Агаар орчин</u>			
1.	Тоосжилт	- Тээвэрлэлт (үйлчлүүлэгчид, барилгын ажлын болон ахуйн хэрэгцээний бүх төрлийн хангамж, түлш, хог хаягдал)	- Улирлын чанартай, тархах хүрээ хомс, хатуу хучилттай замаар төслийн талбай хүрдэг.
1.2	Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, утаа, угаар	- Автомашин	- Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал
<u>Хоёр. Усан орчин</u>			
2.1	Хатуу болон шингэн хог хаягдал	- Ахуйн болон шатах тослох материалын хаягдал - Бохир ус дамжуулах хоолойн бүрэн бус байдал - Хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас асгарах, гоожих	- Хөрс болон хөрсний ус бохирдох магадлалтай. - Хур борооны усаар угаагдаж хөрсний ус бохирдуулна.
<u>Гурав. Хөрс</u>			
3.1	Элэгдэл, эвдрэл,	- Явган жим, зам гарах, дагтарших, талхлагдах	-Хэмжээ хязгаарлагдмал -Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөж болно -Хөрс эвдэрч элэгдэж болно. - Ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой.
3.2	Бохирдол	- Ахуйн хог хаягдал - ШТМ-ын хаягдал - Хаягдал дугуй, сэлбэг хэрэгсэл	-Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар өөрчлөгдөнө.
<u>Дөрөв. Ургамал бүрхэвч</u>			
4.1	Ургамлын талхлагдал	-Автомашин болон явган хүний зам, мөр	-Хэмжээ хязгаарлагдмал
4.2	Ургамлан нөмрөг устах	- Нэн ховор, ховор ургамлыг таньж мэдэхгүй устгах	- Төрөл, зүйл өөрчлөгдөж болно. -Төрөл, зүйл устаж болно. -Хэмжээ хязгаарлагдмал
4.3	Хордолт	- Ахуйн хог болон шатах тослох материалын хаягдал	-Ургамлын биомассын хэмжээ багасна - Ургамлан бүрхэвч эргэлт буцалтгүй устаж болно - Ургамлын генд өөрчлөлт орж болно
4.4	Талхлагдах	- Хүний хөл хөдөлгөөн, үйл ажиллагаанд байнга өртөж буй зөрөг зам, жим, - Ашиглалтын талбай, барилга объектуудын орчин	- Ургамлын төрөл зүйл устаж болно - Ургамлыг нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж болно.
<u>Тав. Ан амьтан</u>			
5.1	Хордолт	- Шатах тослох материалын болон ахуйн хаягдал	-Хөрсөн дэх бичил биетэн, шавьж хорхой үрэгдэж болно. -Амьтдын удамшил генд өөрчлөлт орох магадлалтай

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
<i>Зургаа. Нийгэм эдийн засгийн орчин</i>			
6.1	Үйлчилгээний төв, зочил буудал, газрын теннисний талбай	- Эдийн засгийн чадавхи дээшилнэ	-Хүний танин мэдэхүйд дэвшилттэй, соёлыг түгээх зэрэг эерэг нөлөө их
6.2	Үндсэн хөрөнгө	- Татварын эх үүсвэр	- Улсын төсөвт хувь нэмэр оруулах
6.3	Шинээр ажиллагсад авна	- Ажлын байр шинээр бий болно	- Орон нутгийн иргэдийн ахуй амьдралд тус дөхөм үзүүлнэ. - Тогтмол бус

Дээрх ажлын хүрээнээс үүсэх нөлөөллүүдийг бууруулах, сэргийлэх зорилгоор дараах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

3.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго

3.1.1. Үндсэн зорилго, зорилт

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ-ын үндсэн зорилгыг хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхын хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах зорилтыг хангана.



Үүнд:

1. БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг нөхөн сэргээлтэд тавих шаардлагын хэмжээнд хүргэх;
2. БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
3. БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно;

Уг “Улаан эрэг, Айлтын жалга-1 алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл”-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөллүүд дээр үндэслэн Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан журам, мөн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, зэрэг ажлууд багтсан.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **22.711.800** төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах аргазүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж өгсөн.

3.2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

3.2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч нь хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахдаа төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлэх шаардлагатай.

3.2.1.1. Агаарын болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт 2. Агаарын болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаар - Газар шорооны ажлаас үүсэх тоос - Хайрга, цемент, бусад материалыг ачиж буулгах үед үүсэх тоос - Авто машины хөдөлгүүрээс ялгарах утаа	Хэрэгцээнээс илүү сул гадарга, овоолгыг бага байлгахын тулд ажлыг зохистой хуваарилах	Ойр орчмын талбай эвдрэх	-	250000	250000	Үйл ажиллагааны хүрээнд	Ажлын үед	MNS ISO 4227:2002, “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө”
Хөндсөн хуурай гадарга, элсний овоолго сул шороог салхитай өдрүүдэд услах.		Төслийн талбай болон ойр орчимд тоос тархана.	-	250000	250000	Үйл ажиллагааны хүрээнд	Цаг агаарын байдлаас хамаарна.	MNS 4585:2016, “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”	
Хөрс, хогийг ачааны машинаар зөөхдөө хучлага хэрэглэх		Төслийн талбай болон ойр орчимд тоос тархана.	-	250000	250000	Үйл ажиллагааны хүрээнд	Өдөр бүр	MNS 6063:2010, “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ”	
Газар шорооны үйл ажиллагааг салхины хурд, чиглэлийг харгалзан орчинд нөлөө багатай нөхцөлд гүйцэтгэх		Аюулгүй ажиллагаа хангахаас гадна болон ойр орчимд тоос босохоос сэргийлнэ.	-	250000	250000	Үйл ажиллагааны хүрээнд	Өдөр бүр	MNS 5885:2008, “Агаарт байх бохирдуулах бодисын	
Техникийн нөхцөл хангасан тоног төхөөрөмж ашиглах.		Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.	-	-	-	Үйл ажиллагааны хүрээнд	Өдөр бүр	MNS 5885:2008, “Агаарт байх бохирдуулах бодисын	

		Тээврийн хэрэгсэлд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Төсөв санхүү болон ажил удааширна.	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Өдөр бүр	хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага”
		Ашиглаагүй үед техник, төхөөрөмжийг даруй унтрааж байх. Хөдөлгүүрийг 5 минутаас илүү сул асаахгүй байх.	Төслийн ойр орчимд агаар бохирдол үүснэ.	-	-	-	Үйл ажиллагааны хүрээнд	Ажлын үед	
		Хог, хаягдлыг шатаахгүй. Хаягдал, ялангуяа органик хаягдлыг ялгалгүй овоолохгүй байх	Төслийн орчимд агаарын бохирдол үүснэ	-	500000	500000	Үйл ажиллагааны хүрээнд	Өдөр бүр	
		Гадаргын ус болон газрын доорхи усны нөөц							
2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц -Ундны усны эрүүл ахуй -Аюулгүй ажиллагаа -Усны бохирдол	Төсөл хэрэгжих эзэмшил болон хариуцан хамгаалах талбайг үерийн болон гадаргын усны урсацаас хамгаалах зорилгоор далан байгуулах,	Аюулгүй байдлыг хангах		500000	500000	Үйл ажиллагааны хүрээнд	Өдөр бүр	MNS 4586:1998, “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 6148:2010, “Усны чанар.
		Газар доорх хэрэглээний шугамуудын нарийвчилсан байршлыг мэдэж авах, гэмтээх тохиолдолд гэрээгээр зохицуулах	Ус тасалдах, төсөв зардал нэмэгдэх	-	-	-	Үйл ажиллагааны хүрээнд	Ажлын үед	Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” Ус ашигласны төлбөр (Засгийн газрын 2005 оны 7-р тогтоол)
		Төсөлд ашиглах усны хэрэгцээг хангахдаа зөвшөөрөгдсөн эх үүсвэрүүдээс ус авах, ажлын талбай руу усны машинаар	Төслийн орчимд	-	500000	500000	Үйл ажиллагааны хүрээнд	Ажлын үед	

		авчрах ус, ажлын талбайд том саванд хадгалсан усаар хангана.							
Хөрс болон ургамлан бүрхэвч									
3	Хөрсөн бүрхэвч	Ашиглалтын дор өртөх газрын хэмжээг хамгийн бага хэмжээнд байлгах	Төслийн талбай болон түүний ойр орчимд	-	-	-	Үйл ажиллагааны хүрээнд	Өдөр бүр	MNS 3297:1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн
		Техникийн шаардлага, зураг төслийн төлөвлөлтөөс бусад газар шимт хөрсийг талхлахаас сэргийлэх	Төслийн талбай болон түүний ойр орчимд	-	-	-	Үйл ажиллагааны хүрээнд	Ажлын үед	үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ” MNS 5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах.
		Төслийн хүрээний газрын хэмжээнд талбайн тохижилтыг хийх, халцарч зулгарсан хөрсөн гадаргуугийн хэмжээг багасгах	Төслийн талбай болон түүний ойр орчимд	-	-	-	Үйл ажиллагааны хүрээнд	Өдөр бүр	Техникийн ерөнхий шаардлага” MNS 5916:2008, “БО. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”
		Шинээр өртөх газрын шимт хөрсний үеийг зайлшгүй урьдчилан хуулж хадгалах эсхүл ногоон байгууламжинд эргүүлэн ашиглах	Төслийн талбай болон түүний ойр орчимд	-	1000000	1000000	Үйл ажиллагааны хүрээнд	Ажлын үед	MNS 5850:2008, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
							Үйл ажиллагааны хүрээнд	Ажлын үед	
Төслийн төлөвлөлтийн ажлын үед хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрөгдсөн цэгт	Төслийн талбай болон түүний ойр орчимд	-	500000	500000	Үйл ажиллагааны хүрээнд	Ажлын үед	MNS 5914:2008, “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт”		

	хаяж зайлуулах							
	Шатахууны тос тосолгооны материал алдагдсан тохиолдолд цэвэрлэж хоргүйжүүлэх арга хэмжээ авах	Төслийн талбай болон түүний ойр орчимд, хөрсний ус, хөрс бохирдох	-	500000	500000		Үйл ажиллагааны хүрээнд	Ажлын үед
	Нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэх	Төслийн талбайн ойр орчимд	-	-	-		Үйл ажиллагааны хүрээнд	Ажлын үед
НИЙТ ЗАРДАЛ					4500000			

3.3. Техникийн нөхөн сэргээлтийн зардал

Айлтын жалга-1, Улаан эрэгийн алтын шороон ордын ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагааны улмаас газрын гадаргын төрх байдал өөрчлөгдөж доройтох төдийгүй газрын хэвлийд нөлөөлөл үүснэ. Сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах үүднээс үйл ажиллагааны туршид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Олборлолтоос гарсан шороо болон овоолгын талбайг хамгийн бага хэмжээнд байлгах
- Голоос ус татах шугам хоолой байрлуулсан газар, далан суваг шуудууг булж тэгшлэх, дэнжилсэн хана мөргөцгийг налуулах, нарийвчилсан тэгшилгээ, хэлбэршүүлэлт хийх;
- Уурхайн олборлолтоос бусад эвдэрсэн газрыг буцаан нөхөн сэргээх;
- Уурхайн ашигласан талбайг тэгшлэх хэлбэршүүлэх замаар техникийн нөхөн сэргээлтийг төсөл хэрэгжих хугацаанд хийж гүйцэтгэх шаардлагатай;

Хүснэгт 3. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, зардал

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Эвдэрсэн болон ашиглалт явуулсан талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	дэнжилсэн хана мөргөцгийг налуулах, нарийвчилсан тэгшилгээ, хэлбэршүүлэлт	Төслийн талбай болон түүний орчимд эвдэрсэн газарт	га	2.2	1.000.000	4.800.000	Төсөл хэрэгжих хугацаанд хийгдээд явна.	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 5914 : 2008

		хийх;							
2	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд биологийн нөхөн сэргээлт хийх	Үржил шимт хөрс бэлтгэх, мод сөөг тариалах, хашаа хайс барих	Төслийн ил задгай үлдсэн талбайд	ГА, Ш КГ	1 га талбайд биологи хийх Зүлэгжүүлэлт, мод тарих /300ш/	600000 5000	1.920.000 1.500.000	Төсөл хэрэгжих хугацаанд хийгдээд явна.	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916 : 2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918 : 2008 MNS5918:2008эвдэрсэн газрыг ургамалжуулах, MNS6258:2011 суулгацны нүхийг бэлтгэх, суулгах
НИЙТ ЗАРДАЛ							8.220.000		

3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Уг төслийн үйл ажиллагаатай холбоотой нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал үүсэхээргүй байна.

3.5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх
- Төслөөс шууд өртөж нөлөөлөгдөхөөргүй цэгүүдийг хамгаалах ажиллагаа, соёлын ба үнэт өв дурсгалтай газрыг хамгаалах төлөвлөгөө,хөтөлбөрийг боловсруулахдаа төв, орон нутгийн удирдах байгууллага,мэргэжилтнүүд,орон нутгийн олон нийтийн байгууллага, ШУА-ын Археологийн Хүрээлэн зэрэгтэй зөвлөлдөнө.Энэ төлөвлөгөө, хөтөлбөрийг төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө төлөвлөж мөрдөх.

Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Төслийн үйл ажиллагааны явцад Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй.	Хэрэв төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төслийн талбайд	-	Тухайн үед нь шийдэх	Тухайн үед нь шийдэх	Төслийн үйл ажиллагааны бүхий л үед	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/ ,

3.6. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, ослын сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	1. Хүний буруутай үйл ажиллагааны улмаас галын аюул гарах 2. Байгалын үзэгдлээс үүсэх сөрөг нөлөөлөл 3. Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө	Байгаль орчныг хамгаалах, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах. Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах.	Төслийн нийт ажилчид Төслийн талбай болон түүний ойр орчимд	2 удаа	225.000	450.000	4 сар	MNS 5390:2004, “ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS ILO OSH 1:2003, “ХААЭА-н удирдлагын тогтолцооны талаарх удирдамж”
		Анхны тусламжийн багаж хэрэгсэл, эмийн сан байршуулах.	Төслийн талбайд	1 удаа	500.000	500.000	Ажлын үед өдөр бүр	MNS ILO OSH 0:2003, “ХААЭА. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага
		Төслийн тухай мэдээллийн самбар, ажил эхлэх, дуусах хугацаа, Гүйцэтгэгчийн нэр, холбоо барих хаяг, талбайн удирдах ажилтан, ачааны машинуудын явах зам, төслийн зохион байгуулалт зэргийг мэдээлнэ.	Төслийн ойр орчимд амьдарч буй иргэд мэдээлэл авах	2 ширхэг самбар /2м * 1 м харьцаатай/	300.000	300.000	1 удаа 2 байрлалд хийж байрлуулах.	
2		Үерийн даланг шинэчлэн засварлах				Дотоод зардлаар		
3		Шүүрэлтийг бууруулах зорилгоор нуурын даланг сэргээх	Төслийн талбайд					

НИЙТ ЗАРДАЛ						1.450.000		
--------------------	--	--	--	--	--	------------------	--	--

3.7. Хог хаягдлын менежментийг төлөвлөгөө

Хүснэгт 6. Хог хаягдлын менежмент

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Хог, хаягдлын эко-ээлтэй менежмент хэрэгжүүлж	Төслийн талбайд	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	
		Хаягдлыг хамгийн бага түвшинд байлгах, дахин ашиглах, тусгаарлах	Төслийн талбайд	-	-	--	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	
		Таглаа сайтай саванд хогийг хийх, хадгалах, хольж хийхээс сэргийлж өнгөөр тэмдэглэх,	Төслийн талбайд	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр		
		Хатуу, осолтой хаягдлыг тусгайлан битүүмжилж, хаяг тавин хадгалах	Төслийн талбайд	ш	250.000	1	250.000	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
		Хогийн цэгт хаях хогийг багасгахын тулд хаягдлыг ашиглаж, сайжруулдаг, дахин боловсруулдаг хүмүүс, байгууллагатай сүлжээ үүсгэх.	Төслийн талбайд	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Ажлын үед	
2	Үйлдвэрийн	Технологийн хэрэглээний хатуу хог хаягдлыг хог тээврийн гэрээний дагуу ачуулах,	Төслийн талбайд	Удаа	100.000	4	400.000	Барилгын ажлын үед сард 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
3		Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх. задлах бодис худалдаж авах зардал				-	1.375.000		
	НИЙТ ЗАРДАЛ						2.025.000		

3.8. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсэнээр төслөөс үүсэх сөрөг нөлөөлөл түүнийг бууруулж арилгах боломжгүй хүчин зүйлүүд, нөлөөллийн түвшинг төслийн судалгааны ажлын үед тодорхойлоогүй хүчин зүйлс /амьтадын амьдрах орчин, нүүдэл/ тэдгээрийг

төслийн хэрэгжих орчны экосистем, биологийн олон янз байдлын хувьд төсөөтэй төсөл хэрэгжих орчныг төлөөлж чадахуйц талбайг орон нутгийн засаг захиргаа, иргэдийн санал хүсэлтийг харгалзан үзэж талбайгаа сонгон авч хамгааллын арга хэмжээний ажлуудыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлсэнээр орчны нөхцлийг сайжруулахад үндсэн гол зорилго оршино.

Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Хийгдэх ажил	2024 оны зардал	Хариуцах эзэн
-Нөхөн сэргээлтэнд хэрэглэх ургамлын үрийг бэлдэх -Талбайн хэлбэржүүлэлт, ургамалжуулалтын ажлыг хийж гүйцэтгэх -Дүйцүүлэн хамгаалсан талбайд хяналт мониторинг хийх	5.000.000	Уурхайн дарга

Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай талбайг 2024 оны 7-р сард уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа жигдэрсэн үед Төв аймгийн холбогдох байгууллага болон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газруудыг зааж өгөн хийгдэх ажлуудын төлөвлөгөө гарган гэрээ байгуулж ажиллах талаар аймгийн Байгаль орчны газраас мэдэгдсэн.

Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн

Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төсөл хэрэгжих 5 жилийн хугацаанд 40000 модыг сум, багтай хамтран тарьж арчлан ургуулахаар төлөвлөсөн бөгөөд 2024 онд 5000 ширхэг мод тарьна.

№	Модны нэр	Тоо ширхэг	Зардал
1	Голт бор	250	Дотоод зардлаар мод худалдан авч тарьна.
2	Агч	250	
3	Бургас	250	
4	Хайлаас	2000	
5	Улиас	250	
6	Харгана	2000	
	НИЙТ	5000	

3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


Энэхүү төслийг хэрэгжүүлэх явцад БОМТ-ний тайланд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

ОХШХ нь байгаль орчин, нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно.

Цаашдаа БОХТ-г улам боловсонгүй болгох, байгаль орчин, нийгэм-эдийн засгийн болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг илүү нарийвчлан тогтооход ашиглагдах боломжтой. Хяналт шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлнэ.

Энэ хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлыг төсөл хэрэгжүүлэгч тал бүрэн хариуцах тул мэргэжлийн хүн авч ажиллуулах эсвэл мэргэжлийн байгууллагатай гэрээлэн ажиллах хэрэгтэй. Хяналт шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар, орон нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтын доор гүйцэтгүүлэх зэргээр оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй.

Орчны хяналт шинжилгээний хүрээнд дээж авах цэгүүд



-  Агаарын дээж авах цэг
-  Хөрсний дээж авах цэгүүд
-  Усны дээж авах цэг

Жилд 3 удаа дээж авах бөгөөд дээжийг 5, 7, 10 саруудад заасан цэгүүдээс авч итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж байх шаардлагатай.

Зураг 3. Дээж авах мониторингийн цэгийн зураг

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
1	1	2	3	4	5	6	7	8
	Агаарын чанар / CO ₂ , NO ₂ , SO ₂ , / /Тоос нийт (PM10, PM2.5) Дуу чимээ, шуугиан, доргио /	Уурхай, хотхон, эрүүл газар /ажил явагдаж байгаа үед/	2 удаа /5, 9 сард/	2	200.000	400.000	Дуу чимээний шинжилгээг дБА24 цагийн хэмжилтийн дундажаар тооцож авна.	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016
2	Хөрсний чанар / Хөрсний механик бүтэц, хими физикийн шинж чанар, хүнд металлын бохирдол, /	Уурхай, эрүүл газар	2 удаа 5, 9 сард	2	110000	220.000	Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлнэ.	MNS 5850:2008
3	Усны чанар / Усны чанарын үндсэн үзүүлэлт болон анион, катион, хүнд металл /	Нуур болон хэрэглээний ус	2 удаа 5, 9 сард	2	323400	646.800	Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлнэ.	MNS 900:2005 MNS 4586:1998
НИЙТ ЗАРДАЛ						1.266.800		

3.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 9. Компани удирдлагын зүгээс хийж гүйцэтгэх ажлууд

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөл	Хэрэгжүүлэх хуваарь		Хариуцах албан тушаалтан	Тайлбар
			2024 он			
			6 сар	9 сар		
	Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион	250000	2024 оны 6-р сард ажил эхлэхээс өмнө.	2024 оны 9-р сард ажилчдад	Захирал, Инженер	Төслийн талаарх мэдээллийг оршин суугчид авна. Мөн

1	байгуулж, хамруулах /Төслийн ажилтан тус бүрийг болзошгүй ослын үед ажиллах сургалтад хамруулж дадлагажуулах./						зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх боломжтой
2	Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг ажилчдад анхааруулах, гал унтраах багаж хэрэгслийг бэлэн байлгах, нэгэнт гарсан тохиолдолд холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэж, гал түймрийг богино хугацаанд унтраах аргыг ажилтнуудад эзэмшүүлэх		Ажил эхлэхээс өмнө сургалтын ажилчдад зааж өгөх шаардлагатай.	Ажилчид болон иргэдэд	Ажил дуусахаас өмнө.	Ерөнхий инженер	Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авснаар хүний эрүүл мэнд болон эд материалынд учрах сөрөг нөлөөллийг урьдчилан сэргийлэх боломжтой болно.
	НИЙТ ЗАРДАЛ	250000					

3.10.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоог тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог хууль тогтоомжид заасан хүрээнд аль болох өргөн хангах, тэдэнд ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 10. БОМТ-ний биелэлтийн тайланг хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов / он.сар/	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Төлөвлөгөө батлуулах	БОМТ	2024.6	-	БОАЖЯ

буюу БОАЖЯ					
Сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч	Хэрэгжилтийг хянуулах	БОМТ	2024.6	-	Төв аймгийн БОГазар
Тухайн төсөл хэрэгжих бүс нутагт байгаа хүмүүст тайлагнах	Тайлангийн танилцуулга	БОМТ	2024.6	-	Төсөл хэрэгжүүлэгч
Аймаг, сумын засаг захиргаа	Хэрэгжилтийг тайлагнах	БОМТ	2024.10	-	Төсөл хэрэгжүүлэгч
БОАЖЯ ,Аймгийн БОГ,	Хэрэгжилтийг тайлагнах	БОМТ	2024.11	-	Төв аймгийн БОГазар

ДҮГНЭЛТ

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчноо хамгаалах, нийгмийн хариуцлагын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Төв аймгийн Заамар сумын нутагт байрлах “Их ундарга майнинг” ХХК-ийн Айлтын жалга-1, Улаан эрэгийн алтын шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргааг доор харуулав.

Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгтгэл

№	Хийгдэх ажил	Зардал /төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээ	4500000
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2025000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1450000
4	Техник, биологийн нөхөн сэргээлтийн зардал	8220000
5	БОМТ-ний хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	250000
6	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	5000000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1266800
	Нийт зардал	22.711.800

Менежментийн зардлыг дээрх байдлаар 1 жилийн хугацаанд хийгдэх ажлаар бодож тооцоолон 22.711.800 төгрөгийг төлөвлөгөө гаргасан бөгөөд тухайн төслийн буюу “Айлтын жалга-1, Улаан эрэгийн алтын шороон ордыг ил аргаар ашиглах төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулах явцдаа дээрх менежментийн төлөвлөгөөний зардлаас илүү зардал гаргах боломжтой гэж үзэж байгаа бөгөөд тухайн зардлыг “Их ундарга майнинг” ХХК үйл ажиллагааны зардал болон байгууллагын дотоод зардлаар нөхөн зарцуулан гэж тооцлоо.